



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/04 УАГ-САГ/2014/126/СТГА-ТШЗ

Төсвийн орлого болгох тухай

Баянзүрх дүүргийн Нийгмийн Халамж үйлчилгээний хэлтсийн Халамжийн сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халамжийн сангаас Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тусламж, хөнгөлөлтөд 19 дүгээр хорооны ахмад настан Ш.Цэрэндуламын хиймэл шүдний төлбөр 120,000 төгрөгийг давхардуулан "Тосонцэнгэл суварга" ХХК-д шилжүүлж, олгосон нь "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д "халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно"...гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон 120,000 төгрөгийг "Тосонцэнгэл суварга" ХХК-иар нөхөн төлүүлж, улсын төсвийн Төрийн сан дахь УАГ-ын 900000601 тоот дансанд 2014 оны 3 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэн, төсвийн орлого болгох
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2014 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга З.Үүрцайх, Сангийн мэргэжилтэн Г.Нансалмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын  
Ахлах аудитор

"Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК-ний  
Захирал

УХА0122

Д.Ганбилэг

Г. Энхмаа

ЗӨВШӨӨРСӨН:

Баянзүрх дүүргийн нийгмийн халамж  
үйлчилгээний хэлтсийн дарга

З.Үүрцайх

Сангийн мэргэжилтэн

Г.Нансалмаа

УКА0047  
5001242